


Written by hanoi
Friday, 15 July 2016 08:15 -

There are no translations available.



Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболдод Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ерөнхий сайд Нгуен Суан Фук 7 дугаар сарын 14-ний одор бараалхав.

Улсын Их Хурлын дарга М.Энхболд хэлэхдээ “Эрхэмсэг ноён Нгуен Суан Фуктэй уулзаж байгаадаа баяртай байна. Таны АСЕМ-ын Дээд твшний 11 дүгээр уулзалтад оролцож буй, мон Монгол Улсад Ерөнхий сайдын урилгаар хийж байгаа албан ёсны айлчлал бол манай хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг ойрын ирээдвйд хогжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Монгол Улс анх удаа эх орондоо зохион байгуулж буй АСЕМ-ын Дээд хэмжээний уулзалтын бэлтгэл ажилд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ дагалдах уулзалтуудад Вьетнам Улс онцгой ач холбогдол огч, толоологчид оролцуулж байсан талархал илэрхийлье. Монгол Улс уламжлалт найрсаг харилцаатай, Зүүн Омнод Ази дахь түвш орон Вьетнам Улстай эдийн засгийн үр огоожтэй, харилцан ашигтай хамтын ажиллагаагаа оргожүүлэн хогжүүлэх эрмэлзэлтэй байна” гэв.

Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ерөнхий сайд Нгуен Суан Фук, Улсын Их Хурлын даргыг цаг зав гарган хүлээн авч уулзсанд талархал илэрхийлэв. Мон тэрээр энэ удаагийн айлчлал нь хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргахад чухал ач холбогдолтой гэдэгтэй санал нэгтэй байгаагаа тэмдэглэлээ.

Онгорсон хугацаанд БНСВУ, Монгол Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа амжилттай үргэлжилж ирсэн богоод ирэх жилүүдэд хоёр орны харилцаа хамтын ажиллагааг хэрхэн хогжүүлэх талаар Монгол Улсын Ерөнхий сайдтай санал солилцсон болохоо дуулгалаа. Түүнчлэн парламент хоорондын хамтын ажиллагааг хогжүүлэх талаар хоёр улс идэвхтэй ажиллан, оргон хүрээтэй хамтран ажиллах бололцоо байгааг Ерөнхий сайд Нгуен Суан Фук онцлон тэмдэглэв.

Written by hanoi
Friday, 15 July 2016 08:15 -

Улсын Их Хурлын дарга М.Энхболд Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ерөнхий сайдад Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэлийн Иргэдийн Толоологчдийн хурлын сонгуулийн талаар мэдээлэл огов. 2016 оны 06 дугаар сард Монгол Улс анх удаа Улсын Их Хурал болон Аймаг, нийслэлийн Иргэдийн Толоологчдийн хурлын сонгуулийг хамт явуулсан. Монгол Ардын Нам энэ удаагийн Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн үр дүнд Улсын Их Хуралд 66 суудал авсан тул ирэх 4 жилийн хугацаанд тор засгийн эрхийг барьж үйл ажиллагаа явуулах юм. Ингэхдээ БНСВУ-тай харилцаж байсан уламжлалт харилцаа, хамтын ажиллагааны байр суурь хэвээрээ үргэлжилнэ гэдгийг Улсын Их Хурлын дарга онцлон тэмдэглэлээ.

Мөн тэрбээр, манай хоёр орны харилцаа, хамтын ажиллагаанд парламент хоорондын харилцаа чухал байр суурь эзэлдэг. Парламентын бүлгүүд болон хоёр орны парламентын Тамгын газар хоорондын хамтын ажиллагааг илүү нягт оргожүүлэн, ингэснээр хоёр орны харилцааг хөгжүүлэхэд эрх зүйн талаасаа дэмжлэг туслалцаа үзүүлэх бололцоог эрэлхийлэн парламент хоорондын хамтын ажиллагааг орнүүлэх нь зүйтэй хэмээн хэлсэн юм.

Уулзалтын үеэр талууд олон улсын тавцан дахь хамтын ажиллагааны талаар харилцан ярилцаж, санал солилцов.